



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/92

Ховд

Өмчилсөн газрын хэмжээ, хаяг
өөрчлөх

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 55 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 143 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинээр хийгдсэн кадастрын зураглалын дагуу өмчилсөн газрын хэмжээ талбай, хаяг, суурь үнэ, зөрүүтэй гарсан 3 иргэний хүсэлтийн дагуу холбогдох захирамжийн заалтуудад өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан иргэдийн газрын хэмжээ, хаяг, суурь үнэлгээнд өөрчлөлт оруулан гэрчилгээг хүчингүй болгож дахин олгохыг Жаргалант сумын Засаг дарга (Ц.Цогтбаяр), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (С.Хоролсүрэн) нарт даалгасугай.

3. Энт захирамж гарсантай холбогдуулан 2023 оны А/883 дугаар захирамжийн 11 дэх хэсэг болох Б.Марал, Б.Цолбоо нартай холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 0223

Zan A/92/Kh